

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН
САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.09.28

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан батлуулсан нэгжүүдийн сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

Үнэлэлт

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Сар	Ажилтнуудын төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
Захиргаа, санхүүгийн хэлтэс									
VII сар	6	5	-	-	-	-	1	-	83.34
VIII сар	9	4	3	-	-	1	1	-	77.78
Дүн	15	9	3	-	-	1	2	-	80.00
Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс									
VII сар	14	13	1	-	-	-	-	-	99.29
VIII сар	11	11	-	-	-	-	-	-	100
Дүн	25	24	1	-	-	-	-	-	99.60
Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс									
VII сар	6	6	-	-	-	-	-	-	100
VIII сар	4	4	-	-	-	-	-	-	100
Дүн	10	10	-	-	-	-	-	-	100
Нийт дүн	50	43	4	-	-	1	2	-	93.80

Дүгнэлт:

1. VII сарын цагийн бүртгэлээр мэргэжилтэн М.Оюун-Ундрэм 15, Д.Дарьсүрэн 11, С.Золзаяа 8, Э.Осоржамаа 6, Г.Байгалмаа 14 өдөр ажиллаж Д.Дарьсүрэн 5, С.Золзаяа 2, Э.Осоржамаа 10, Д.Пүрэвдолгор 16 хоногийн ээлжийн амралт эдэлж, С.Золзаяа 3 өдрийн сургалт, 2 өдрийн чөлөө, Г.Байгалмаа 2 өдрийн хариуцлагатай жижүүрийн амралт авсан байна.

2. VIII сарын цагийн бүртгэлээр М.Оюун-Ундрэм 23, Д.Дарьсүрэн 10, С.Золзаяа 5, Э.Осоржамаа 11, Г.Байгалмаа 17 өдөр ажиллаж, Д.Дарьсүрэн 13, Э.Осоржамаа 12, С.Золзаяа 3 хоногийн ээлжийн амралт эдэлж, Г.Байгалмаа 6 өдрийн чөлөө, С.Золзаяа 12 өдрийн сургалт, 3 өдрийн акт авсан байна.

3. Ажилтнуудын ажлын цагийн бүртгэл байгаа боловч ЗСХ нь VII, VIII сард хэлтсийн төлөвлөгөө нэгтгэж төлөвлөөгүй, эйбл системд холбоогүй, батлуулаагүй байна.

4. ДҮАМ-д 2022.07.01-ний өдрөөс 18 хоногоор тооцож ээлжийн амралт олгож, мэргэжилтэн М.Оюун-Ундрэмд ажлыг хүлээлцүүлж, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр захирлын 2022.06.16-ны өдрийн Б/30 дугаар тушаалын 3 дахь заалтаар үүрэг болгосон ч ЗСХ-ийн сарын төлөвлөгөө нэгтгэж батлуулах, тайлагнах ажил хийгдээгүй байна.

5. VII сард Э.Осоржамаа 6 ажлыг төлөвлөж эйбл системд оруулж, тайлагнасан бол М.Оюун-Ундрэм, Г.Байгалмаа, Д.Дарьсүрэн, С.Золзаяа нар Хөдөлмөрийн дотоод журам, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх, баримт бичгийг цахимаар солилцох зааврын дагуу сарын төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй байна.

6. VIII сард Г.Байгалмаа 2 ажил төлөвлөж, эйбл системд оруулж, биелэлтийг тайлагнасан бол Д.Дарьсүрэн, М.Оюун-Ундрэм нар тус бүр 2 ажил төлөвлөж эйбл системд оруулсан хэдий ч биелэлтийн тайлан гаргаагүй, Э.Осоржамаа 3 ажил төлөвлөж хэрэгжүүлсэн боловч эйбл системд холбоогүй, тайлагнаагүй, С.Золзаяа сарын ажил төлөвлөөгүй, тайлагнаагүй байна.

7. ТНУАСХ-ийн ажилтнуудын холбогдох журам, зааврын дагуу сарын ажлыг бүрэн төлөвлөж, тайлагнасан байна.

8. VII сарын цагийн бүртгэлээр З.Мөнхтуяа, Б.Жавзандулам нар 15 өдөр ажиллаж, Б.Жавзандулам 1 өдрийн чөлөө авсан, Н.Номин 10 хоногийн ээлжийн амралт эдэлж, 6 өдөр ажилласан, Д.Бат-Оргил 16 хоногийн ээлжийн амралт эдэлсэн бол VIII сарын цагийн бүртгэлээр Д.Бат-Оргил 20 өдөр ажиллаж, 2 хоногийн ээлжийн амралттай, З.Мөнхтуяа 6 өдөр ажиллаж, 17 хоногийн ээлжийн амралттай, Б.Жавзандулам, Н.Номин нар 23 өдөр ажилласан байна. ГХБАБМХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Бат-Оргилын VIII сарын цагийн бүртгэл бүрэн хэдий ч зохих журмын дагуу сарын ажил төлөвлөж, тайлагнаагүй байна.

Санал зөвлөмж:

1. Хөдөлмөрийн дотоод журмын:
 - “5.1.6.Төвийн болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн нэгжүүд сар бүр төлөвлөгөө боловсруулж ажиллана. Төлөвлөгөөг тайлант сарын 05-ны дотор батлуулна.”,
 - “5.2.1.Ажилтан ажлаа нэгжийн даргын өмнө хариуцна.”,
 - “5.2.2.Ажилтнууд энэ журмын 5.1.6-д заасан төлөвлөгөөний биелэлтийг тухайн сарын 30-ны дотор эйбл системээр тайлагнаж, нэгжийн даргад цахимаар хянуулна.”,
 - “5.2.3.Нэгжийн дарга нэгжийн сарын төлөвлөгөөний биелэлтийг дараа сарын 05-ны дотор Захиралд цахимаар танилцуулна.” гэж заасан дотоод хэм хэмжээг мөрдөж ажиллах.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА

Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
ХШҮМ



Z. Oorjimaaya

Ц.ОЮУНБАТ

Э.ОСОРЖАМАА